



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрдэнэмандал сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2025/17/-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.open.audit.mn
Архангай аймаг
2025 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа
Утас: 7033-3141
Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn
Аудитын менежер Д.Нэргүйбаатар
Утас: 7033-2860
Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn
Ахлах аудитор П.Цэцэгдулам
Утас: 7033-3019
Цахим хаяг: Tsetsegdulap@audit.gov.mn

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	13
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	
3.5.3 Нэмэлт төсөв.....	
3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл	
3.5.6 Тайлант хугацааны ерөнхий чиглэлийн талаар	
4. АУДИТЫН ТАЙЛАН	
4.1 Ерөнхий зүйл.....	
4.2 Материаллаг байдал.....	
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	14
5.1 Төлбөрийн акт.....	14
5.2 Албан шаардлага.....	15
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МУЕА	Монгол улсын ерөнхий аудитор
БГАҮТХ	Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөр хураамж
ЗДТГ	Засаг даргын тамгын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2025.02.19 № 22

танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Эрдэнэмандал сумын ЗДТГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Архангай аймгийн Эрдэнэмандал сумын ЗДТГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

1. Албан хаагчдын хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны урамшууллыг зөрүүтэй тооцсон, хувь хүний орлогын албан татвар суутгаагүй 6,149.8 мянган төгрөгийг илүү олгосон;
2. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж төсвийн хөрөнгөөр 2,998.8 мянган төгрөгийн биеийн тамирын хувцас худалдан авсан;
3. Төсвийн хөрөнгөөр 29,278.7 төгрөгийн тоног төхөөрөмжийг шууд худалдан авч, худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй;
4. Сумын засаг даргын орлогч, багийн Засаг дарга нарт цалингийн сангаас нийт 12,891.1 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон;

Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйл 5.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 8 дугаар зүйлийн 8.1, 12 дугаар зүйлийн 12.1, 12.1.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 31 дүгээр зүйлийн 31.1, 34.1 дэх заалт, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэг, Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар", Засгийн газрын 2024 оны

83 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны албан хаагчдад мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.3 дахь заалтыг зөрчсөн, аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Засгийн газрын 83 дугаар тогтоолоор "Төрийн захиргааны албан хаагчдад мөнгөн урамшуулал олгох журам" батлагдсаны дагуу тус байгууллагын төсвөөс 43,902.0 мянган төгрөгийг албан хаагчдын хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны урамшуулалд зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Төсвийн захирагчийн орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага хөтөлбөрийн хүрээнд нийт 6 арга хэмжээг хэрэгжүүлэхээр 1,136,987.7 мянган төгрөгийн төсөв зарцуулахаар батлагдсанаас, гүйцэтгэл 92.1 хувь буюу 1,047,548.7 мянган төгрөгийг зарцуулж 91,684.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна. Энэ нь цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардлыг үндсэн цалин, нэмэгдэл, унаа хоолны хөнгөлөлт, урамшуулал гэсэн зардлын эдийн засгийн ангиллаар төлөвлөөгүйтэй холбоотой байна.

Бусад асуудлын хэсэг

Эрдэнэмандал сумын ЗДТГ нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 11 үндсэн зорилтын хүрээнд 46 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 30 арга хэмжээг 90-100 хувь, 15 арга хэмжээг 70-80 хувь, 1 арга хэмжээг 30 хувь биелүүлж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг сумын Засаг даргаас 88.0 хувьтай үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж тогилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	84,709,479.90	116,883,346.47
33	АВЛАГА		13,700,000.00
335	Бусад авлага		13,700,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага		13,700,000.00
34	УРЬДЧИЛГАА		
35	БАРАА МАТЕРИАЛ	84,709,479.90	103,183,346.47
354	Хангамжийн материал	84,709,479.90	97,063,346.47
3542	Аж ахуйн материал	35,932,979.90	48,002,546.47
3547	Бусад хангамжийн материал	48,776,500.00	49,060,800.00
356	Мал амьтад		6,120,000.00
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	10,916,660,546.79	11,026,306,609.06
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	10,916,660,546.79	11,026,306,609.06
392	Биет хөрөнгө	10,576,880,546.79	10,686,526,609.06
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,155,261,911.03	2,302,261,911.03
39202	Хуримтлагдсан элэгдэл	-207,293,015.85	-283,610,780.71
39203	Авто-тээврийн хэрэгсэл	231,605,405.00	365,900,343.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-109,743,464.09	-122,908,917.27
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	73,730,445.92	106,899,145.92
39206	Хуримтлагдсан элэгдэл	-45,492,344.62	-63,172,980.32
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	29,911,114.00	83,811,114.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-13,335,164.89	-21,626,298.37
39209	Зам, гүүрийн байгууламж	4,595,672,108.00	4,597,672,108.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-269,065,596.93	-517,988,673.96
39214	Бусад үндсэн хөрөнгө	4,369,782,445.00	4,577,197,345.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-862,453,295.78	-1,186,207,707.26
39216	Дуусаагүй барилга, байгууламж	503,000,000.00	723,000,000.00
39217	Ном	125,300,000.00	125,300,000.00
393	Биет бус хөрөнгө	339,780,000.00	339,780,000.00
39301	Програм хангамж	2,450,000.00	2,450,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	337,330,000.00	337,330,000.00
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	11,001,370,026.69	11,143,189,955.53
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	11,001,370,026.69	11,143,189,955.53
51	Засгийн газрын хувь оролцоо	11,001,370,026.69	11,143,189,955.53
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,402,068,016.00	1,402,068,016.00
512	Хуримтлагдсан үр дүн	9,504,447,798.97	9,646,267,727.81
5121	Өмнөх үеийн үр дүн	9,504,447,798.97	9,504,447,798.97
5122	Тайлант үеийн үр дүн		141,819,928.84
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	94,854,211.72	94,854,211.72
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	11,001,370,026.69	11,143,189,955.53

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,855,530,221.00	2,004,648,114.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,135,000.00	815,564,838.00
120	Нийтлэг татварын бус орлого	7,135,000.00	815,564,838.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,135,000.00	8,415,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,135,000.00	8,415,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	751,784,500.00	801,029,838.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	10,000,000.00	6,120,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,086,610,721.00	1,189,083,276.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	297,808,821.00	58,265,576.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		2,050,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	346,800.00	4,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	252,848,021.00	3,151,576.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	44,614,000.00	49,064,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	788,801,900.00	1,130,817,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	788,801,900.00	1,130,817,700.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,777,189,004.43	1,846,308,185.32
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,777,189,004.43	1,846,308,185.32
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,708,635,935.30	1,703,522,185.32
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	459,512,071.00	638,225,336.00
210101	Үндсэн цалин	318,663,686.00	409,239,498.00
210102	Нэмэгдэл	98,367,845.00	188,250,238.00
210104	Урамшуулал	35,280,540.00	32,735,600.00
210105	Гэрээт ажлын хөлс	7,200,000.00	8,000,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	56,617,481.99	78,390,588.58
210201	Тэтгэврийн даатгал	38,879,062.76	54,427,299.15
210202	Тэтгэмжийн даатгал	4,592,117.89	6,374,103.81
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,673,694.24	3,574,339.26
210204	Ажилгүйдлийн даатгал	861,143.35	1,471,688.97
210205	Эрүүл мэндийн даатгал	8,611,463.75	12,543,157.39
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	66,502,515.68	60,503,000.00
210301	Гэрэл, цахилгаан	12,197,877.08	10,000,000.00
210302	Түлш, халаалт	47,604,000.00	43,000,000.00
210303	Цэвэр, бохир ус	6,700,638.60	7,503,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	42,619,297.20	51,734,788.43
210401	Бичиг хэрэг	6,000,500.00	6,000,000.00
210402	Тээвэр, шатахуун	13,335,256.00	19,599,995.00

Архангай аймгийн Эрдэнэмандал сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,999,831.20	6,000,000.00
210404	Ном, хэвлэл	506,800.00	3,862,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	13,538,750.00	8,272,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,238,160.00	7,999,993.43
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	35,283,577.06	28,461,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,423,992.00	21,100.00
210602	Тавилга		100,000.00
210604	Урсгал засвар	29,859,585.06	28,340,000.00
2107	Томилолт, зочны зардал	18,881,700.00	25,000,000.00
210702	Дотоод албан томилолт	18,881,700.00	25,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,709,065.00	14,751,196.42
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,844,843.00	12,300,120.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,154,200.00	
210803	Даатгалын үйлчилгээ		34,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	250,000.00	347,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	250,000.00	353,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,110,000.00	1,697,076.42
210807	Газрын төлбөр	100,022.00	20,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,010,510,227.37	806,456,175.89
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	315,291,384.00	96,763,700.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	695,218,843.37	709,692,475.89
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	68,553,069.13	142,786,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	35,521,500.00	51,102,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	30,721,500.00	
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		43,902,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,800,000.00	7,200,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	33,031,569.13	91,684,000.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	33,031,569.13	91,684,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	78,341,216.57	158,339,928.68
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	45,412,399.82	16,519,999.84
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	45,412,399.82	16,519,999.84
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-45,412,399.82	-16,519,999.84
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	32,928,816.75	141,819,928.84

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,093,745,721.00	1,197,498,276.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,135,000.00	8,415,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	7,135,000.00	8,415,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,135,000.00	8,415,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,135,000.00	8,415,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,086,610,721.00	1,189,083,276.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	297,808,821.00	58,265,576.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		2,050,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	346,800.00	4,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	252,848,021.00	3,151,576.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	44,614,000.00	49,064,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	788,801,900.00	1,130,817,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	788,801,900.00	1,130,817,700.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,090,069,792.00	1,162,669,576.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,090,069,792.00	1,162,669,576.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,021,516,722.87	1,019,883,576.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	459,358,134.00	638,325,336.00
210101	Үндсэн цалин	318,509,749.00	409,339,498.00
210102	Нэмэгдэл	98,367,845.00	188,250,238.00
210104	Урамшуулал	35,280,540.00	32,735,600.00
210105	Гэрээт ажлын хөлс	7,200,000.00	8,000,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	56,771,418.99	78,290,588.58
210201	Тэтгэврийн даатгал	39,032,999.76	54,327,299.15
210202	Тэтгэмжийн даатгал	4,592,117.89	6,374,103.81
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,673,694.24	3,574,339.26
210204	Ажилгүйдлийн даатгал	861,143.35	1,471,688.97
210205	Эрүүл мэндийн даатгал	8,611,463.75	12,543,157.39
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	66,502,877.88	60,503,000.00
210301	Гэрэл, цахилгаан	12,197,877.88	10,000,000.00
210302	Түлш, халаалт	47,604,000.00	43,000,000.00
210303	Цэвэр, бохир ус	6,701,000.00	7,503,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	42,618,500.00	65,434,800.00
210401	Бичиг хэрэг	6,000,000.00	6,000,000.00
210402	Тээвэр, шатахуун	13,335,300.00	19,600,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,000,000.00	6,000,000.00
210404	Ном, хэвлэл	506,800.00	17,562,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	13,538,400.00	8,272,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,238,000.00	8,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	35,284,071.00	28,461,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,424,071.00	21,100.00
210602	Тавилга		100,000.00
210604	Урсгал засвар	29,860,000.00	28,340,000.00
2107	Томиллолт, зочны зардал	29,558,700.00	25,000,000.00
210702	Дотоод албан томиллолт	29,558,700.00	25,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,709,021.00	14,750,451.42
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,844,821.00	12,300,276.00

Архангай аймгийн Эрдэнэмандал сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,154,200.00	
210803	Даатгалын үйлчилгээ		34,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	250,000.00	350,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	250,000.00	350,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,110,000.00	1,696,175.42
210807	Газрын төлбөр	100,000.00	20,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	312,714,000.00	109,118,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	312,714,000.00	109,118,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	68,553,069.13	142,786,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	35,521,500.00	51,102,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	30,721,500.00	
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		43,902,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,800,000.00	7,200,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	33,031,569.13	91,684,000.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	33,031,569.13	91,684,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	3,675,929.00	34,828,700.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	3,675,929.00	34,828,700.00
	Дотоод эх үүсвэрээр	3,675,929.00	34,828,700.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3,675,929.00	34,828,700.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-3,675,929.00	-34,828,700.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)		
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-н хувь оролцооны дүн
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,402,068,016.00	94,854,211.72	9,504,447,798.97	11,001,370,026.69
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
13	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
17	Тайлант үеийн үр дүн			141,819,928.84	141,819,928.84
19	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,402,068,016.00	94,854,211.72	9,646,267,727.81	11,143,189,955.53

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,136,987,700.00	1,047,548,700.00	89,439,000.00	92.13
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,136,987,700.00	1,047,548,700.00	89,439,000.00	92.13
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,085,885,700.00	996,446,700.00	89,439,000.00	91.76
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	688,347,900.00	638,325,336.00	50,022,564.00	92.73
210101	Үндсэн цалин	678,747,900.00	409,339,498.00	269,408,402.00	60.31
210102	Нэмэгдэл		188,250,238.00	188,250,238.00	-
210104	Урамшуулал		32,735,600.00	-32,735,600.00	
210105	Гэрээт ажлын хөлс	9,600,000.00	8,000,000.00	1,600,000.00	83.33
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	86,043,500.00	78,290,588.58	7,752,911.42	90.99
210201	Тэтгэврийн даатгал	58,509,500.00	54,327,299.15	4,182,200.85	92.85
210202	Тэтгэмжийн даатгал	6,883,500.00	6,374,103.81	509,396.19	92.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,506,800.00	3,574,339.26	1,932,460.74	64.91
210204	Ажилгүйдлийн даатгал	1,376,700.00	1,471,688.97	-94,988.97	106.9
210205	Эрүүл мэндийн даатгал	13,767,000.00	12,543,157.39	1,223,842.61	91.11
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	68,500,000.00	60,503,000.00	7,997,000.00	88.33
210301	Гэрэл, цахилгаан	10,000,000.00	10,000,000.00		100
210302	Түлш, халаалт	50,500,000.00	43,000,000.00	7,500,000.00	85.15
210303	Цэвэр, бохир ус	8,000,000.00	7,503,000.00	497,000.00	93.79
2104	Хангамж, бараа материалын зардал	67,156,800.00	65,434,800.00	1,722,000.00	97.44
210401	Бичиг хэрэг	6,000,000.00	6,000,000.00		100
210402	Тээвэр, шатахуун	19,600,000.00	19,600,000.00		100
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,000,000.00	6,000,000.00		100
210404	Ном, хэвлэл	17,800,000.00	17,562,000.00	238,000.00	98.66
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	9,756,800.00	8,272,800.00	1,484,000.00	84.79
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,000,000.00	8,000,000.00		100
2105	Нормативт зардал				
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	64,400,000.00	59,740,000.00	4,660,000.00	92.76
210601	Багаж, техник, хэрэгсэл	26,400,000.00	26,400,000.00		100
210602	Тавилга	5,000,000.00	5,000,000.00		100
210604	Урсгал засвар	33,000,000.00	28,340,000.00	4,660,000.00	85.88
2107	Томилолт, зочны зардал	25,000,000.00	25,000,000.00		100
210702	Дотоод албан томилолт	25,000,000.00	25,000,000.00		100
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	23,403,200.00	15,148,675.42	8,254,524.58	64.73
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16,197,500.00	12,698,500.00	3,499,000.00	78.4

Архангай аймгийн Эрдэнэмандал сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,280,000.00		4,280,000.00	
210803	Даатгалын үйлчилгээ	100,000.00	34,000.00	66,000.00	34
210804	Тээврийн хэрэгслийн татвар	350,000.00	350,000.00		100
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	350,000.00	350,000.00		100
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,025,700.00	1,696,175.42	329,524.58	83.73
210807	Газрын төлбөр	100,000.00	20,000.00	80,000.00	20
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	63,034,300.00	54,004,300.00	9,030,000.00	85.67
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	63,034,300.00	54,004,300.00	9,030,000.00	85.67
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	51,102,000.00	51,102,000.00		100
2132	Бусад урсгал шилжүүлэг	51,102,000.00	51,102,000.00		100
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	43,902,000.00	43,902,000.00		100
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,200,000.00	7,200,000.00		100
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,136,987,700.00	1,047,548,700.00	89,439,000.00	92.13
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,130,817,700.00	1,039,133,700.00	91,684,000.00	91.89
132001	Орон нутгийн төсвөөс	1,130,817,700.00	1,039,133,700.00	91,684,000.00	91.89
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	6,170,000.00	8,415,000.00	-2,245,000.00	136.39
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,170,000.00	8,415,000.00	-2,245,000.00	136.39
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1		100
3	Төсвийн байгууллага	1	1		100
5	АЖИЛЛАГСАДЫН ТОО	29	29		100
6	Удирдах ажилтан	9	9		100
7	Гүйцэтгэх ажилтан	15	10		66.6
8	Үйлчлэх ажилтан	5	5		100

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Д/Д	Үзүүлэлт	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	58,265,576.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	58,265,576.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	58,265,576.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,151,576.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,151,576.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	55,114,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	55,114,000.00
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	58,265,576.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	58,265,576.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	2,050,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,151,576.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	49,064,000.00
	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	00.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Тайлант онд цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардлаас өндөр дүнгээр хэмнэлт үүссэн байдал ажиглагдаж байгаа тул цалингийн сангийн төлөвлөлт, гүйцэтгэл
2. Мал амьтад нэмэгдсэнтэй холбоотой малын орлого, зардлын бүртгэл, тооцоо, малыг тооллогод хамруулсан бодитоор оршин байгаа эсэхийг шалгахаар төлөвлөсөн.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 25,700.0 мянган төгрөгийн 2 алдаа¹ илэрснийг аудитын явцад залрууллаа.

Залруулсан алдаа:

- Урсгал засварын зардлаас санхүүжүүлсэн 12,000.0 мянган төгрөгийн засварыг үндсэн хөрөнгийн тодруулга тайланд үнэ төлбөргүй хүлээн авснаар бүртгэснийг залрууллаа.
- Сумын 100 жилийн ойн арга хэмжээг угтан сумын түүхэн ном, төрийн захиргааны байгууллагын түүхэн замнал ном бүтээхэд урьдчилгаанд шилжүүлсэн 13,700.0 мянган төгрөгийг тайлан балансад авлагаар тусгууллаа.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4, 14.4.2 дахь заалтууд, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, ангилал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар залруулаагүй **52,818.4** мянган төгрөгийн зөрчил² илэрч 9,148.6 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 43,669.7 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлээ.

Аудитаар залруулагдаагүй 5 зөрчилтэй асуудлын материаллаг алдаа зөрчил нь **52,818.4** мянган төгрөг бөгөөд тогтоосон материаллаг байдлын дүн 11,369.8 мянган төгрөгөөс их байгаа тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

5.1.1. Албан хаагчдын хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны урамшууллыг зөрүүтэй тооцож, хувь хүний орлогын албан татвар суутгаагүйтэй холбоотой 6,149.8 мянган төгрөгийг илүү олгосон байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 -т "Албан татвар төлөгчийн дараах орлогод албан татвар ногдоно, 6.3.1-т "цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого", 21 дүгээр зүйлийн 21.1-т "Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасны дагуу тухайн жилийн орлогыг тодорхойлоход 0-120 000 000 хүртэлх төгрөгийн албан татвар ногдуулах орлого олсон тохиолдолд 10 хувиар"... албан татвар ногдуулна", Засгийн газрын 2024 оны 83 дугаар тогтоолын 2.3-т "Мөнгөн урамшууллын хэмжээг тодорхойлохдоо Төрийн албаны тухай хуулийн 51.3-т заасныг баримтлан тухайн төрийн захиргааны алба хаагчийн сүүлийн 12 сарын үндсэн цалингийн дунджийг 6 дахин нэмэгдүүлж тооцно" гэсэн заалтуудыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт буцаан төлүүлэх төлбөрийн акт тогтоолоо.

5.1.2 ЗДТГ-ын бараа үйлчилгээний бусад зардлаас албан хаагчдад биеийн тамирын хослол, өмсгөл худалдан авахад 2,998.8 мянган төгрөгийг зарцуулсан байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д "Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно", 12 дугаар зүйлийн 12.1-д "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно", 12.1.4-т "хуулиар зөвшөөрөөгүй бусад" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт буцаан төлүүлэх төлбөрийн акт тогтоолоо.

5.2 Албан шаардлага

5.2.1 Сумын Засаг даргын орлогч, багийн Засаг дарга нар буюу улс төрийн албан тушаалтнуудад цалингийн сангаас нийт 12,891.1 мянган төгрөгийн урамшуулал олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-т "Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална" 4.1.3-т "үр ашигтай байх", 4.1.6-д "Сахилга баттай байх", 4.1.9-д "хариуцлагатай байх" 4.2.3-т "Хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагаа, арга хэмжээ нь хамгийн бага зардлаар хамгийн өндөр үр дүнг хангахад чиглэсэн байх", 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох"-ыг хориглоно гэсэн заалтыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх, таслан зогсоох албан шаардлага хүргүүлээ.

5.2.2 Тайлант онд багаж техник хяналтын зардлаас 25,728.9 мянган төгрөгийн, байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 3,549.8 мянган төгрөг нийт 29,278.7 мянган төгрөгөөр i5 компьютер, 3 үйлдэлт принтер, ерson өнгөт принтер худалдан авахдаа ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй шууд худалдан авалт хийсэн байна.

Энэ нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 10 дугаар зүйлийн 10.1-д "Захиалагч тендер шалгаруулалтыг энэ хуулийн Дөрөвдүгээр бүлэгт заасан аргаар зохион байгуулна", 31 дүгээр зүйлийн 31.1-д "Захиалагч ерөнхий гэрээний аргаар худалдан авахаас бусад тохиолдолд хуульд заасан төсөвт өртөгт үндэслэн тендер шалгаруулалтын дараах аргын аль нэгийн дагуу зохион байгуулна", 34 дүгээр зүйлийн 34.1-д "Захиалагч нийт төсөвт өртөг нь харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээний тендер шалгаруулалтыг харьцуулалтын аргаар цахим системд үнийн санал дуудаж зохион байгуулж болно", Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар" -ыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх, таслан зогсоох албан шаардлага хүргүүлээ.

5.2.3 Тайлант оны түлш халаалтын тогтмол зардлаас ЗДТГ-ын 2024.12.18-ны өдрийн А/37 дугаар тушаалаар ЗДТГ-ын аюулгүйн нөөц үүсвэрт цахилгаан мотор худалдан авахад 1,500.0 төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т "Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлээ.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
мэдээллийг буруу бүртгэсэнтэй холбоотой	1	12,000.0			1	12,000.0	1	12,000.0				
мэдээллийг орхигдуулсантай холбоотой	1	13,700.0	1	13,700.0			1	13,700.0				
Нийт дүн	2	25,700.0	1	13,700.0	1	12,000.0	2	25,700.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Улс төрийн албан хаагчид үр дүнгийн урамшуулал олгосон	1	12,891.1			1	12,891.1						
хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны урамшууллыг зөрүүтэй тооцож, хувь хүний орлогын албан татвар суутгаагүй	1	6,149.8	1	6,149.8								
Төсвийн хөрөнгөөр биеийн тамирын хувцас авсан	1	2,998.8	1	2,998.8								
ХАА зохион байгуулаагүй	1	29,278.7			1	29,278.7						
Зориулалт бус зарцуулсан	1	1,500.0			1	1,500.0						
Дүн	5	52,818.4	2	9,148.6	3	43,669.8						